

Төв эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүдийн хүлээгдлийн мэдээний нэгтгэл

2024 оны 07 дугаар сарын хүлээгдлийн мэдээг Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Гэмтэл согог судлалын үндэсний төв, Геронтологийн үндэсний төв, Хүрээ амаржих газар зэрэг 4 байгууллага ирүүлсэн. Үүнд:

1. Улсын хоёрдугаар төв эмнэлэг

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл өмнөх саруудаас харьцангуй буурсан үзүүлэлттэй байна. 2024 оны 6 сарын 30-ны өдрийн байдлаар нийт 127 үйлчлүүлэгч 4-с дээш хоногийн амбулаторийн үзлэгийн хүлээгдэлтэй байсан бол 7 сарын 31-ний байдлаар нийт 68 хүний хүлээгдэлтэй байна. Хамгийн их хүлээгдэлтэй амбулаторийн тусламж, үйлчилгээнд Хоол боловсруулах эрхтэн судлалын эмчийн үзлэг орж байна. Хүснэгт 1.

Хүснэгт 1. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Кабинетын нэр	Хүлээгдлийн хугацаа			Бүгд
		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Хоол боловсруулах эрхтэн судлал	1	1	17	19
2	Бөөр судлал	1	-	2	3
3	Мэс засал судлал	-	3	11	14
4	Мэдрэл судлал	-	1	8	9
5	Нүд судлал	1	-	3	4
6	Зүрх судас	-	-	13	13
7	Чих хамар хоолой судлал	1	-	2	3
8	Эмэгтэйчүүд судлал	-	1	2	3
	НИЙТ	4	6	58	68

Нийт хүлээгдлийн дийлэнх илүү буюу 85% нь 7-с дээш хоногийн хүлээгдэлтэй байна.

Тус эмнэлэгт оношилгоо хийлгэхээр 29 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сараас 10 үйлчлүүлэгчээр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Эход харуулахаар 2, рентген оношилгоо хийлгэхээр 20, MRI оношилгоо хийлгэхээр 7 үйлчлүүлэгч тус тус 2-с дээш хоног хүлээж байна. Хүснэгт 2.

Хүснэгт 2. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн оношилгооны хүлээгдэл

№	Оношилгоо	Хүлээгдлийн хугацаа			Нийт
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног	
1	Хэвлийн эхо	1	-	1	2
2	Рентген зураг	15	4	1	20
3	MRI/CT	-	1	6	7
	Бүгд	16	5	8	29

Тус эмнэлэгт лабораторийн шинжилгээ өгөхөөр нийт 14 үйлчлүүлэгч 3-с дээш хоног хүлээж байна. Хүснэгт 3.

Хүснэгт 3. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн лабораторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Шинжилгээний нэр	Хүлээгдлийн хугацаа		
		3-6 хоног	7-14 хоног	15-с дээш хоног
2	Бактерлогийн шинжилгээ	-	1	-
3	Биохимийн шинжилгээ	-	-	3
4	Серологи	-	2	2
5	Иммунологи	1	2	3
	НИЙТ	1	5	8

Тус эмнэлгийн орны хүлээгдэл өмнөх сартай адил, нийт 190 үйлчлүүлэгч 3-с дээш хоног ор хүлээж байна. Эмэгтэйчүүдийн эмгэг судлалын тасагт хэвтэхээр 42, Хоол боловсруулах эрхтэн судлалын тасагт хэвтэхээр 41 хүн тус тус ор хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарч байна. Хүснэгт 4.

Хүснэгт 4. Улсын хоёрдугаар төв эмнэлгийн хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Тасгийн нэр	Хүлээгдлийн хугацаа			
		3-6 хоног	7-14 хоног	15-30 хоног	БҮГД
1	Эмэгтэйчүүдийн эмгэг судлал	16	23	3	42
2	Хоол боловсруулах эрхтэн судлал	4	7	30	41
3	Чих, хамар, хоолой судлал	5	7	20	32
4	Уламжлалт эмчилгээний тасаг	-	15	15	30
5	Мэдрэлийн эмгэг судлал	4	2	1	7
6	Мэс засал судлал	21	10	-	31
7	Урологи	7	-	-	7
	НИЙТ	57	64	69	190

2. Гэмтэл согог судлалын үндэсний төв

Тус эмнэлгийн амбулаторийн тусламж, үйлчилгээ авахаар нийт 235 үйлчлүүлэгч 2-с дээш хоног хүлээж байгаа нь өмнөх сартай ойролцоо үзүүлэлттэй байна. Хүүхдийн мэс заслын кабинетд үзүүлэхээр 64, гар сарвууны бичил мэс заслын эмчид үзүүлэхээр 61 үйлчлүүлэгч тус тус хүлээж байгаа нь хамгийн их хүлээгдэлтэй тусламжид хамаарна. Хүснэгт 5.

Хүснэгт 5. Гэмтэл согог судлалын үндэсний төвийн амбулаторийн тусламж, үйлчилгээний хүлээгдэл

№	Үзлэгийн кабинетын нэр	Хүлээгдэлтэй үйлчлүүлэгчийн тоо	Нийт
---	------------------------	---------------------------------	------

		3 хоног	4-6 хоног	7-с дээш хоног	
1	Нурууны мэс засал	3	21	10	34
2	Хүүхдийн мэс заслын кабинет	31	28	5	64
3	Насанд хүрэгсдийн гэмтэл	23	21	10	54
4	Гар сарвууны бичил мэс заслын кабинет	30	22	9	61
5	Толгойн мэс засал	-	-	4	4
6	Сэргээн засах эмчилгээ	4	2	8	14
7	Ясны эмгэгийн мэс засал	-	-	1	1
8	Зүрх судасны эмчийн үзлэг	3	-	-	3
	НИЙТ	94	94	47	235

ГССҮТ-ийн MRI оношилгооны багаж гэмтэлтэй байгаа ба 56 үйлчлүүлэгч уг шинжилгээг хийлгэхээр хүлээж байна. Рентгенд харуулахаар 1, хэвлийн эход харуулахаар 3 үйлчлүүлэгч тус тус хүлээж байна. Харин бусад оношилгоо хүлээгдэлгүй байна. Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний хувьд хүлээгдэл багатай, 3 үйлчлүүлэгч 3-6 хоног ор хүлээж байна.

4. Хүрээ амаржих газар ТМЭ

Тус эмнэлэг 2024 оны 7 сард хүлээгдэлгүй ажилласан байна.

5. Геронтологийн үндэсний төв

Тус төвд дүрс оношилгоо хийлгэхээр 8 үйлчлүүлэгч 4-6 хоног хүлээж байна.

- Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын Улсын гуравдугаар төв эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Арьсны өвчин судлалын үндэсний төв, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Өргөө, Амгалан амаржих газрууд, Эх, хүүхэд, нярайн төв-2, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хүүхдийн төв сувилал болон Нийслэлийн эрүүл мэндийн газар нь 2024 оны 7 сарын хүлээгдлийн мэдээг ирүүлээгүй болно.